

НОН ХОРЧИНЫ АРВАН ХОШУУНЫ “НУТАГ” ХЭМЭЭХ НИЙГМИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ

АЛТАНГАРАГ

Товч агуулга: Уг өгүүлэлд орон нутгийн түүх, соёлын баримт болон зохиогчийн тухайн газарт хийсэн хээрийн шинжилгээний эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан Нон хорчины арван хошууны нийгмийн зохион байгуулалтын өвөрмөц шинжийг судлан өгүүлэхийг зорив.

Түлхүүр үг: Ар Хорчин, Нон Хорчин, арван хошуу, нутаг, нийгмийн зохион байгуулалт

Бид XV-XVI зууны үед Хасар ноёны 14-р үеийн ач Хүймөнх Тасхар, Хорчин аймгаас нэг бүлэг харьяатаа дагуулан Хянганы нурууг даван өмнө зүгт Нун мөрний сав газарт нутагшсаныг, Хөлөн нуурын хавиар ард хоцрон нутагласан “Ар Хорчин аймга”-аас ялгаж “Нон Хорчин аймаг” хэмээн дуудан заншсан юм. Хорчин аймгийн харьяанд тэр хавьд нутаглаж байсан Жалайд, Дөрвөд, Горлос, зэрэг аймгийг оруулж аваад хамтаар Айшин гүрэнд дагаар орсоны дараа эргээд Чин улсын хошуу чуулганы дүрмийн эрхээр өөрчлөгдөн Нон Хорчин аймаг нь “Жирэмийн чуулган” хэмээгдэн, арван хошуунд хуваагджээ. Тухайлбал, Хорчин баруун гарын өмнөд хошуу, Хорчин баруун гарын дунд хошуу, Хорчин баруун гарын Хойд хошуу, Хорчин зүүн гарын өмнөд хошуу, Хорчин зүүн гарын дунд хошуу, Хорчин зүүн гарын хойд хошуу, Жалайд хошуу, Дөрвөд хошуу, Горлосын хойд хошуу, Горлосын өмнөд хошуу, зэрэг арваг хошуу болжээ. Эдгээр хошууны харьяат ардын аман түүхэнд Нон Хорчины арван хошуу буюу Нон арван хошуу хэмээн уламжилж ирсэн баримт байна.

Нон арван хошуунд бусад чуулгантай адилгүй нийгмийн үндсэн зохион байгуулалт хамтлаг (угсаатан зүйн томъёолол “нутаг”) гэж бий. Судлаачид үүний тухай хараахан нарийн судалсангүй бөгөөд Чин улсын үеийн чуулган, хошуу, сум хэмээх тогтолцоонд хамааруулан үзсээр байна. Албаны баримт бичиг болон угсаатан зүйн аргыг уяалдуулж судлавал зарим асуудал маш тодохой тайлбарлагдаж магадгүй. Монгол сурвалж бичиг “Алтан хүрдэн мянган хигээст бичиг”-т (Хайссиг, 1958), (Морикава, 1973) Цахарын отгийг “нутаг” хэмээн тэмдэглэсэн

байна. Үүнээс өөр сурвалж бичигт отгийг “нутаг” хэмээн тэмдэглэсэн жишээ харагдсангүй. Чин улсын үеийн хошуу чуулганы дүрэм нь Манжийн эрхшээлийн үе хүртэл үргэлжилсэн тул үнэндээ холын биш түүх юм. Арав гаруй жилийн өмнө миний бие хээрийн шинжилгээний ажлаар явж байхад Нон арван хошууны зарим нутгийн настайчуудын ярианд дээр дурдагдсан хошуу чуулганы дүрмийн бүтэцтэй адилгүй мэдээ байсан явдал нь миний сонирхолыг татаж байсан бөгөөд уг хээрийн судалгаа нь Жалайд хошууны уугуул суугуул Монгол (нутгийн иргэд) гэгдсэн монголчуудын тухай эрдэм шинжилгээний харааснаас ажиглах анхны сэрэлт болсон юм. Настайчуудын ярианд сум гэдэг үе суудал яагаад байдаггүй вэ? зөвхөн “нутаг”-ийн тухай яриа байдаг. Үүнээс үзвэл чуулган хошуу сумаас гадна ямар нэгэн зохион байгуулалтын бүтэц байсан бололтой. Яг энэхүү зүйл нь Нон арван хошууны нийгмийн бүтэцийн онцгой чанарыг харуулж байсан ч байж магад.

“Нутаг” хэмээх ухагдахууны талаар судлаачид тус тусад нь авч үзсэн судалгаа үгүй боловч зохих хэмжээний материал хуримтлагдаад байна. XX зууны ерээд оны Жирим аймаг хийгээд хошуудын орон нутгийн ойллогын албан гэрийн найруулан хэвлэсэн хошууны ойллогод “Нутаг” тэмдэглэгсэн байдаг. Ойрын жилүүдэд Б.Шувуу, Цогмандал, Төмөр зэрэг судлаачид бас нутгийн тухай хамаа бүхий материалыг нөхвөрлэжээ¹. Материалын эрэлт хувь хүний сонголтын чанартай түүхийн яриа болохоор цаашдаа нөхвөрлөн тэмдэглэх чухалтай юм. Гэвч аман түүхийг өгүүлэгчид он цаг улирах тусам тутам цөөрч байгаа тул бүр материалыг шалган магадлахад төвөгтэй байна. “Манж хаант улс”-ын ноёрхлын үед “Хянган дөрвөн муж”-ын харъяан дахь Монгол оронд “нутаг” хуваах дүрмийг улируулан хэрэгжүүлсэнээс тийм материал хэсэг бусад үлдсн дүнд зарим нь чухал сураг мэдээ хангаж байна. Би Монголын өндөрлөгийн нутаг байгалийн түүхчилсэн судлалын хараанаас тус асуудлыг анхааран, хэдэн өгүүлэлд “Нутаг болон Нон арван хошуу” дахь “нутаг”-ийн баларсан шалтгааныг өгүүлэв². Халх Монголын нийгмийн зохион байгуулалт дахь “отог” Нон Хорчины “нутаг” нь адил тал харагдана³. Иймэрхүү судалгааны арга зүйн талаар эрхбиш сурвалж бичгээр

¹ 波少布《蒙古“努图克”人原始文化遗存对其发展的影响》（黑龙江民族与历史文化）中央民族出版社，1993年。朝克满都拉《试论清代哲里木盟十旗“努图克”》《黑龙江民族丛刊》2005年，第6期（总89期）。博尔济吉特特木尔《科左中旗台吉家族领地划分》《嫩科尔沁故事》（创刊号），2013年，187页

² 参照阿拉腾嘎日嘎《近现代内蒙古游牧变迁研究》（中国蒙古学文库系列专著）辽宁民族出版社，2012年；《20世纪蒙古人的牧业环境—以嫩科尔沁地区为例》《蒙古史研究现状与未来》（吉田顺一监修，早稻田大学蒙古研究所，明石書店，2011年，第379—389页；《嫩科尔沁“努图克”之消失》《中国社会科学院人类学年刊》2012年，第120—131页

³ 岡洋树《清代蒙古蒙旗制度研究》，东方书社，2007年

тодорхойлох цулгуй хараасыг тэвчиж, архивын материалыг ашиглах болон тухайн газрыг хээрийн шинжилгээний аргатай уяалдуулбал сая Чин улсын үеийн хошуу, чуулганы дүрмийн цаана халхлагдаж байгаа Монголын нийгмийн уламжлалт тогтолцоог тодруулах боломжтой. Мөн “Монголын нийгмийн байгуулалын түүх” зэрэг өнгөрсөний судалгаан дахь хамаа бүхий онолтыг засварлаж болно⁴. Уг өгүүлэл нь голдуу орон нутгийн түүх, соёлын материал болон зохиогчийн тухайн газар дахь баялаг байцаалтын материалыг ашиглажээ. “Нутаг” хэмээх зохион байгуулалтыг товч өгүүлэхийн хамт Нон арван хошууны нийгмийн тогтолцооны өвөрмөц шинжийг хөндөн задлан шинжлэхийг хичээв.

Нэг. “Нутаг” гэх үгийн утга

“Нутаг” гэх (nutu) “Монголын нууц товчоо” болон хөшөөн бичгүүдэд “nuntu” гэж тэмдэглэв. Алтан товч, Эрдэнийн товч, Алтан хааны тууж, (XVII зуун) зэрэг сурвалж бичигт, уул бичгийн хэлний “nuntu” дахь “n” дагавар гээгдэж “nutu” болжээ⁵. Одоо Дундад улсын хязгаар дахь зарим цөөн нутгийн аялгуунд “nonto” буюу “nuntu” хэмээн хэлэгдэж байна⁶. Алтайн язгуур хэлнээс бусад төрөл хэлэнд тус үг мөн байдаг. Жишээлбэл, Манж үгэнд “nugta” хэмээх үг нь Монгол хэлний “нутаг” гэсэн үгтэй ижил утгатай байдаг.

“Нутаг” гэдэг үгийн соёлын ухагдахууныг оновчтой орчуулж тайлбарлахын төлөө, гадаадын эрдэмтэд дахин давтан тунгааж өнгөрсөн. Жишээлбэл, Мориками (1970 он) нүүдэл малжилын хүрээ хэмжээ гэж ойлгосон бол Озава (1984) нүүдэлчин монголчуудын амьдарлын тойрог гэж үзжээ. Ёшида “Малжих хүрээ хэмжээ”⁷ гэж үзсэн бөгөөд Мориками-ийн тайлбарласантай адил байна. Уг үгийн гол утга нь ч нүүдэл малжилын хүрээ хэмжээ болох юм. Малчдад авч хэлбэл яриангүй амьдарч орших үндэс суурь болно. Орчин цагийн Монгол хэлэнд “эх нутаг” гэх салбар утга гардаг нь үнэндээ “нутаг” гэдэг үгээс үүсэлтэй юм.

Нутаг бол малчдын нүүдлийн хүрээ, амьдралын хүрээ үүсэл, нутаглан малжих хүрээ хэмжээ болон, Монголын өндөрлөгийн нүүдэлчин аймаг ер нь их багын ялгаа байдаг боловч бүгд өөр өөрийн нутагтай байдаг. Латтиморын дурдсан аль нэг овог аймгийн их нутаг нь бас хэд хэдэн бага нутагтай байжээ. Малжих өрх

⁴ Б.Я.Владимирцов. Монголчуудын нийгмийн байгууллын түүх. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо: 1981

⁵ Б.Я.Владимирцов. Монголчуудын нийгмийн байгууллын түүх. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо: 1981

⁶ 小沢重男, 《元朝秘史全訳》(上), 風間書房, 1984年, 第27—29頁

⁷ 吉田順一, 《アルタン=ハーン伝》, 風間書房, 1998年, 第123頁

болгон бас өөрийн нутгийн хүрээ хэмжээтэй байжээ. Энэхүү их багын адилгүй “нутаг” хооронд тодорхой зааг байхгүй юм. Овоо, уул хайрхан, гол мөрөн, нуур, бүрд зэргийг зааж нутгийн хэмжээг тодохойлно⁸.

XV зуунаас хойш Нон Хорчинд “нутаг” хэмээх үг нь дээр дурдагдсан мэт өргөн утга байхаас гадна бас өөр нэгэн утгатай болжээ. “Монгол толь бичигт”-т (1997) анх удаа шинэ утгат холбогдсон үгсийг оруулжээ. Толь бичиг дэх тайлбарыг үндэслэвэл, Нутаг нь малжилын хүрээ хэмжээг заахаар барахгүй, эх нутаг зэрэг утга байх бөгөөд Өвөр Монголын тариалах орон, хагас тариалах хагас малжилын оронд бас засгийн байгууламжийг зааж бараг сумтай тэнцэнэ гэжээ⁹. Өвөр Монголын тариалах орон ба хагас тариалах хагас малжих орон гэдэг нь одоогийн Тунгляо хот, Улаанхад хот хийгээд аймаг, өөрөөр хэлбэл Жирмийн чуулга, Зуу-Удын чуулга, Зостын чуулганы хэсэг газар орныг заана. Хэдийгээр толь бичиг дэх тайлбар дөхөм болсон боловч анх удаа уншигчдад тусгүй нөгөө нэг утгыг дамжуулжээ. Хэрвээ нон Хорчин дахь “Нутаг” хэмээх ойлголтын улирал хувьслын эх адгийг баттай эзэмшихгүй бол буруугаар ойлгоход хүрнэ. Учир нь Чин улс, Иргэн улсын үеийн “нутаг” хийгээд Манж ийн эрхшээлийн үеийн нутаг болон Өвөр Монголын өөртөө засах ордон байгуулагдсаны дараа хэрэгжүүлсэн “нутаг” нь адилгүй ухагдахуун юм.

XX зууны дундаж сүүлч үеэс нутаг нь аажмаар Өвөр Монголын зүүн орны засаг захиргааны хуваарь нэгж буюу засаг захиргааны нэр болж хувирав. Харин Хянган аймгийн Хорчин баруун гарын өмнөд хошууны Улаанмод нутаг нь хамгийн сүүлийн үе хүртэл үлдэж байсан нутаг юм.

Нон арван хошууны нутаг нь Б.Я.Владимирцовын өгүүлэн тайлбарласан эртний отогтой адилавартай байна. Түүний үзэхээр Монгол хэлний отог гэдэг үг бол дундад Азийн Согд язгуур хэлний утаг хэмээх үгээс хувиран ирсэн даруй нутаг дэвсгэр суурь буурь гэх утгатай гэжээ. Турк хэл Монгол хэл Тунгус хэлэнд нутаглан малжих хүрээ суурь буурь, суурьшил гэх утгатай. Цэргийн явдлын утгаас хэлвэл Монгол хүний отог гэдэг нь мөн цэрэг ангийн нэгжийг зааж хэд хэдэн отгийн цэрэг нийлж нэг хошууг бүрэлдүүлнэ¹⁰. Гэхдээ Нун Хорчин дэх ийм нэгж нь нутаг байж мэдэх юм. Хэрвээ энэ хоёр үгийг нэг л язгуураас мөрдөж болоход хүрвэл нутаг ба отог нь адил утгатай үг болно¹¹.

⁸ Алтангараг. *XX зууны эхний үеийн Өвөр Монголын зүүн орны малжих нутгийн тухай*. 2004

⁹ Сэцэнцогт. Монгол үгсийн язгуурийн толь. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо: 1981, 578

¹⁰ Б.Я.Владимирцов. Монголчуудын нийгмийн байгууллын түүх. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо: 1981

¹¹ Сэцэнцогт. Монгол үгсийн язгуурийн толь. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо: 1981, 578

Нутаг гэдэг зохион байгуулалт нь бас сүүлийн үеийн Халх Монголын нийгмийн зохион байгуулалт дахь отогтой маш адилавар харагдаж байна¹². Нутаг болон отог нь цөм Чин улсын үеийн хошуу чуулганы дүрмийн хажуугаар буюу зэрэгцэж үлдэж ирсэн хошууны үндсэн зохион байгуулалт болно. Гэхдээ нутаг бол отор нүүдлийн хүрээ хэмжээ болохоор үл баран нийгмийн зохион байгуулалтийн нэр болж үлдсэн юм. Иймээс нутгийг хоёр ишт утгатай гэж ойлгож болно¹³. Харин Халх Монголын отог нь зөвхөн нийгмийн зохион байгуулалтын утгаар үлдэж ирсэн юм.

2. Нон арван хошууны “нутаг”-ийн хуваарь

Нон арван хошуу нь бараг XV зуунаас нутгийн хуваарьтай байжээ. Хээрийн шинжилгээний материалаас харахад нутаг хуваарилахад журамлаж дагах хуультай байсан бөгөөд ус бэлчээр хужирлаг тал зэрэг оторлож малжихад холбогдох чухал элементүүдийг бодолцож “гол мөрнөөр хязгаар болгох” “уул овоогоор төв болгох” аргаар нутаг хуваадаг байсан бололтой. Энэ бол Монголын өндөрлөгийн малжих нийгмийн нутаг хуваах уламжлалт заншил байсан гэж хэлж болно. Харин Чин улсад дагаар орсоны дараа Монгол оронд хэрэгжүүлсэн дүрэм гэж ойлгож таарахгүй. Жалайд аймаг, Дөрвөд аймаг, Горлос аймаг, Хорчин аймгийг дагаж Чин улсад дагаар орохоос өмнө нутаг буюу отог хуваах заншилтай байжээ.

Аймгийн ноён нь хөвгүүдийн тоогоор нутаг хуваадаг. Хэдэн хөвгүүнтэй бол хэдэн нутаг хуваан, нутаг хувьчилсан хөвгүүд нь нутгийн ноён болдог. Энэ бол Нон арван хошууны нутгийн анхны хэлбэр байжээ. Хүрээ хэмжээ нь хувирдаггүй. Гэвч аймгийн ноён нь үргүй буюу өөр ямар нэг зүйлийн шалтгаанаас болж зарим нутгийг нийлүүлэх буюу шинэ нутаг хуваах онцгой байдал бас бий. Иймээс адил бус цаг төрийн үед нутгийн тоо нь ч адилгүй байдаг. Дээр үеийн нутаг хуваасан тоо баримтыг дурьдвал,

Хүснэгт 1.

Хошуу	Нутгийн тоо	Хошуу	Нутгийн тоо
Хорчин баруун гарын хойд хошуу (Гүнгийн хошуу)	4	Хорчин зүүн гарын өмнөд хошуу (Бинт хошуу)	5
Горлосын өмнөд хошуу	3	Хорчин зүүн гарын дундад хошуу (Дархан хошуу)	4
Горлосын хойд хошуу	4	Хорчин зүүн гарын хойд хошуу (Бодлогот чин вангийн хошуу)	10

¹² 《清代蒙古蒙旗制度研究》，岡洋树，东方书社，2007年

¹³ 阿拉腾嘎日嘎《嫩科尔沁地区“努图克”的消失》《中国社会科学院人类学年刊》，2012年，第160页

Жалайд хошуу	12	Хорчин баруун гарын өмнөд хошуу (Засагт хошуу)	12
Дөрвөд хошуу	6	Хорчин баруун гарын дунд хошуу (Түшээт хошуу)	13


Хүснэгтэд тэмдэглэгдсэн нутгийн тоо нь үндсэндээ эл хошуудын анхны засгийн үеийн нутгийн тоо бололтой. Адил бус түүхэн цаг үед нутгийн тоо бас адилгүй. Нэмэгдсэн буюу хасагдсан тохиолдол байна. Үүнээс гадна эл нутаг нь нэг буюу хэд хэдэн нэртэй байсан ба адил бус цаг үеийн адил бус дуудлага байсан бололтой. Нон арван хошуунд нутгийн тоо хамгийн олон нь 13, хамгийн цөөн нь 3 байна. Гэхдээ нутгийн тоогоор нутгийн хүрээ хэмжээний их багыг хэмжээлдэг биш, харин аймгийн ноёны хөвгүүдийн тоогоор нутгийн тоо тогтоогддог байжээ.

Нутгийн ахлагчийг ноён, нутгийн Да буюу их Да, Да ноён гэдэг. ХХ зууны эхний үед ноён гэж дуудаж байснаа хожим нь нутгийн Да буюу их Да гэж дуудах болжээ. 1930-д оны үеийн Япон материалд их Да гэж тэмдэглэж буй. Жалайд хошууны жишээгээр авч үзвэл нутгийн ноён нь эрхбиш Хасарын удмын нэр хүндэт ахмадын дундаас нутгийн ноёдын хурлаар сонгож гаргадаг. Харин хошуу засгаас томилдог албан тушаалтан биш.

Овоо, гол мөрөн, уул даваа, нуур усаар, цэг буюу шугам болгож нутгийн хүрээ хэмжээ хуваах бөгөөд үүнийг нутгийн ард хичээнгүйлэн сахиж журамладаг уламжлалт заншилтай. Хорчин баруун гарын өмнөд хошуу, Жалайд хошуу, Хорчин зүүн гарын өмнөд хошуу, шэрэг хошуудын нутаг нь уул нутгийн уугуул монголчуудын ой цээжинд тодорхой үлдсээр ирсэн бөгөөд нутгийн хүрээ хэмжээгээ их төлөв зурж чадах цээжин зурагтай байжээ. Энэ хошуудын засгийн ордноос зурсан хошууны хязгаарын хуваарь зургийг үндэслэж угийн цээжин зургийн төлөвийг сэргээж болох юм¹⁴. Жалайд хошууны хуучин нутгийн хуваарийг сэргээн зурсан тойм зураг 1,2-оос лавлаж болно.

¹⁴ Walther Heissig “verzeichnis der orientalischen handschriften Supplementband 5.2 Mongolische Ortsnamen Teil II”. Franz steiner verlag gmbh. Wiesbaden 1966

Тойм зураг-1 Жалайд хошууны хуучин “нутаг”-ын хүрээ хэмжээ¹⁵



Тойм зураг-2 Жалайд хошууны хуучин “нутаг”-ыг сэргээсэн зураг¹⁶



¹⁵ 井手俊太郎《哲里木盟蒙地之基础—从兴安各省实态调查观察》《蒙古研究》第三辑，蒙古研究会，1939年（康德六年），第277页插图，270页，275页

¹⁶ Тойм зураг-1 ба хээрийн шинжилгээний материалыг үндэслэж Алтангараг 2004 онд сэргээн зурав.

Тойм зураг 1, 2-т үзүүлсэн мэтээр Жалайд хошууны нутгийн төлөв зураг нь нилээд тодорхой байна. Нутгийг хувиарлах арга нь хошуу засгийн зарлиг захирамжаар биш харин Хасарын хойчисын уламжлалт өмчлөл байсан бололтой. Тойм зурагт нутгийн их төлөв хүрээ хэмжээ болон Манж хаант улсын үед өөрчлөн дугаарласан нутгийг тус тус үзүүлж байгаа болохоор уул нутгийн хүрээ хэмжээг сэргээхэд дутагдаж болшгүй үнэт ховвор материалыг хангаж буй. Чин улсын сүүлчийн үед Монгол нутагт атар хагалбарлах төрийн бодлого хэрэгжүүлсэний дараа уг нутгийн хүрээ хэмжээ багасч эл хошуудын нутгийн тоо ч хасагдав. Одоогийн Өвөр Монголийн харьяанд Нон арван хошуунаас таван хошуу нутаг үлдэж хоцорсноос бусад нь бүр Дундад Иргэн улс, Манж хаант улсын үед, зүүн хойд гурван мужийн шян, жоуд хуваагдан орсон байна.

3. “Нутаг”-ын зохион байгуулалт

Чуулган, хошуу, сум гэх зохион байгуулалт нь Чин улсын үеийн Монголын нийгэмд хэрэгжүүлсэн цэрэг, засаг захиргааны зохион байгуулалт юм. Ока Хирокигийн судалгааг үндэслэвэл, Халх Монголын нийгмийн засаг захиргааны бүтэц нь “аймаг, хошуу, отог” болно. Нон арван хошууны нийгмийн зохион байгуулалтын бүтэц нь зарим талаар Халх Монголын нийгмийн бүтэцтэй адилгүй тал бий. Дараах хүснэгтэд эл хошуудын засаг захиргааны зохион байгуулалтыг харуулсан юм. Үүнд,

Хүснэгт 2. Чин улсын үеийн Жирмийн чуулганы Нон Хорчин арван хошууны засаг захиргааны бүтэц

Хошуу	Нутгийн бараг тоо	Сумны бараг тоо	Гацааны бараг тоо	Айлын бараг тоо
Дөрвөд хошуу	6	21	?	59
Жалайд хошуу	12	?	?	62
Горлос хойд хошуу	4	?	?	113
Горлосын өмнөд хошуу	3	?	50	100
Гүнгийн хошуу	4	16	?	60
Түшээт хошуу	13	22-32	?	65
Засагт хошуу	12	18	?	80
Бодлогот вангийн хошуу	8	32	?	65
Дархан хошуу	4	?	?	80
Бинт хошуу	5	?	?	70

Дээрх хүснэгтийг үндэслэж хэдэн талын магадлал хийж болно. Хошуу нутаг айл гэсэн зохион байгуулалт байсан бололтой. Нон арван хошууны харьяанд сумтай хошуу тав байжээ. Гацаатай хошуу нэг байна. Иймээс Жирэмийн чуулганы арван хошуунд сумын зохион байгуулалт нийтээр оршиж байсангүй бөгөөд тухайн үед гацаа гэх нэр ховор байжээ.

1939 онд нэгэн судлаач Хорчин зүүн гарын дундад хошуу болон Жалайд хошуугаар жишээлэн Өвөр Монголын зүүн орны газар өмчлөлийн асуудлын талаар судалгаа хийсний дүнд Хорчин зүүн гарын дунд хошуу дээр үед дөрвөн нутагтай, тус бүр Дархан чин вангийн угсаа төрлийн 9 гэр нутаг, зоригт Чин вангийн угсаа төрлийн дөрвөн гэр нутаг, Ян ван, Жи вангийн угсаа төрлийн долоон гэр нутаг. Өндөр вангийн угсаа төрлийн 5 гэр нутаг гэж тус тусын хувьчилсан нутагтаа тархан нутаглажээ. Сүүлийн үед хошууны бүх тайж язгууртан, арван бүлэг болгон, бүлэг болгонд нэг Да ноён томилсон ба харьяат ардаа арван нэгэн бүлэг хуваан арван нэгэн залан томилж хамааруулжээ. Да ноён нь эрхбиш тайж язгууртан байх учиртай бол залан ноён зэрэг хэрэггүй, харц албат ч залан сууж болдог байна¹⁷. Жалайд хошууны Аминдархан ноёны 12 хөвгүүд нь хошууны эл нутагт дархан сууж, зүүн гарын 8 нутаг 500 өрх 3000 гаруй хүн амтай, баруун гарын өрх 700 гаруй өрх 4400 гаруй хүн амтай, нийт 12 нутаг хуваажээ. Нутаг бүрд нэг Боржигон овгийн Да ноёнттой. Харьяат ардаа дөрвөн бүлэг хувааж дөрвөн залан томилжээ. Жалайд хошуунд засаг вангаас ондоо сул ван байхгүй тул Хорчин зүүн гарын дундад хошууны нутаг хуваасан байдалтай адилгүй боловч хоёр хошууны нутгийн шинж чанар нь үндсэндээ адил¹⁸. Нягтлавал нутаг бол Хорчин аймгийн ноёдын өмч мөн. Хоёр хошууны харьяатын тоо нэлээд зөрөөтэй. Хэдийгээр харц ардын ахлагчийг залан гэж нэрлэдэг боловч зохион байгуулалтын нэр нь тодорхой биш. Залан болон Да ноён адил бус нэрийдэл. Энд сум буюу хуяг гэх мэтийн үндсэн нэр томъёо мэдэгддэггүй. Үүнээс үзвэл нутаг нь Боржигон овгийн өөртөө засах нийгэм байжээ. Харцын зохион байгуулалт нь нутгийн харьяатаас ондоо заланд хамаарагддаг өөр нэг зохион байгуулалт бололтой. Залан гэх тушаалын хэрэглэсэн нь сумын зохион байгуулалтаас нутгийн зохион байгуулалт руу хандсаныг харуулж байж магадгүй.

Хорчин зүүн гарын Хойд хошуунд “тайжаар овгийн дотоод хэргийг хамааруулсан нутгаар нэгж болгон хуяг гаралтай заланаас энэ нутгийн дотоод

¹⁷ 井手俊太郎《哲里木盟蒙地之基础—从兴安各省实态调查观察》《蒙古研究》第三辑，蒙古研究会，1939年（康德六年），第277页插图，270页，275页

¹⁸ 井手俊太郎《哲里木盟蒙地之基础—从兴安各省实态调查观察》《蒙古研究》第三辑，蒙古研究会，1939年（康德六年），第277页插图，270页，275页

засгийг хамаарна. Бадаргуулт төрийн үед хүн ам нэмэгдсэнээс заланы доор суман зангитай болж бүх хошуунд 32 суман зангитай байв. Суман зангийн доор хүнд, бошог зэрэг тушаалыг бий болгожээ. Энх-амгалангийн 44-р онд (1705) Чин улсын засгаас нутгийн овгийн ахлагч аравны даргыг тохируулах зарлиг буулгаж тайж овгийн дотоод хэргийг хамаарах болжээ. Эл нутагт овгийн ахлагч нэг хүн, овгийн ахлагчийн доор аравны даргад дөрвөн хүн тавьжээ”¹⁹. Энд дурдаж буй сум бол хожим байгуулагдсан засгийн нэгж мөн. Нутгийн залан нь бас Чин улсын засгаас нутгийн дотоод хэргийг хамааруулахаар тохируулсан тушаал мөн.

Чин улсын сүүлч Иргэн улсын эхэн үед Хорчин баруун гарын Хойд хошуу дөрвөн занги 16 сум 4 нутагтай байжээ. Заланг нутгийн залан гэдэг. Нутгийн залангийн хараанд 4-5 сум байна. Зарим нь нэг сумтай байна²⁰. Иймээс нэг нутаг чухам хэдэн сумтай байсан нь тодорхой биш. Хэрвээ сум гэдэг зохион байгуулалт нь Бадаргуулт төрийн үед²¹ хэрэглэсэн бол тэр нь зөвхөн засгийн албан данс эвхмэл бичигт илэрсэн “засаг захиргааны нэгж бололтой”. Дээр дурдсан хоёр хошуунд хэрвээ сумын зохион байгуулалт байж өнгөрсөн бол нутагт дагалдан харьяалагдсан байгууламж төдий. Сум бол цэргийн явдлын зохион байгуулалт болсоны хувьд зөвхөн нутгийн тогтсон эрийн тооны хуягийг хамаарч нутагт дагалдаж байсан нь тодорхой байна. Нутгийн дүрэм ингэж үргэлжилсэн нь нутгийн ноёны сүр хүчийг улам томруулж их ноёны шийдвэрлэсэн хэрэг учирт хошуу засаг ч гар дүрэх хэрэггүй гэдэг хууч яриа бий²². Яг ийм учраас Нон арван хошуунд сум гэх зохион байгуулалт заримдаа харагдаж байсан шалтгаан байж мэднэ. Эл хошуудын нутгийн зохион байгуулалтын будлиантай байдал нь Жирмийн чуулганы арван хошууны нийгмийн бүтэцийг ойлгоход маш их эндүүрэл авчирсанаар үл барам эрдэм шинжилгээнд нэлээд мадаг маргаан дагуулжээ.

Хорчин баруун гарын өмнөд хошуу, хорчин баруун гарын хойд хошууны бодитой жишээнээс үзвэл нэгдүгээр зүйлийн бүтэц хошуу нутаг айлын ард дагалдсан. Хоёрдугаар зүйлийн бүтэц хошуу, нутаг, сум гэсэн хэлбэр оршиж байсан бололтой. Харин бусад хошууд нь бүр нэгдүгээр зүйлийн бүтэц хадгалж, хоёрдугаар зүйлийн бүтэц тодорхой харагддаггүй. Ялангуяа чуулган, хошуу, сум гэх бүтэц байхгүй.

¹⁹ 巴根那《科尔沁左翼后旗志》，内蒙古人民出版社，1993年，第593页

²⁰ Хурца. *Манжийн эрхшээлийн үеийн Өвөр засаг Монгол хошуудын монгол бичгийн данс*. 2007

²¹ 巴根那《科尔沁左翼后旗志》，内蒙古人民出版社，1993年，第593页

²² Хээрийн шинжилгээний материал. Зохиогчийн хувийн архив.

1939 оны үеийн Япон материалд Жалайд хошууны нутгийн харьяанд айл гэдэг нэгж байгууламж байжээ²³. Айл нь мөн айлын хурал гэж хийдэг. Тухайн үед маш их нөлөө үйлдэл бадруулж байв. Айл гэдэг нь хэдэн өрх буюу хэдэн арван өрх нэг газар нутаглаж суухыг хэлдэг.

XX зууны эхний үед суурьшин малжих буюу малжих тариалхыг хавсран эрхлэх хэлбэр илэрсэнээс хойш айлын өрхийн тоо хэдхэн байснаас арваад болж хожим нь аажмаар энд тэнд тархай бутархай айл тосгон бүрэлдсэн байна. Өвөр Монголын зүүн орны айл гэдэг нь Монголын өндөрлөгийн бусад орон нутгийн хот айлтай адилхан утгатай байжээ. Гэвч зүүн орны малчид суурьшин амьдрах болсон нь нилээд эрт болохоор эл айлын өрхийн тоо түргэн нэмэгдэж тариалах явцыг өнгөрүүлээд өнөөдрийнх шиг Хятад маягийн тосгонтой үндсэндээ ялгаагүй болж хувиржээ.

Нэг нутгийн харьяанд өрхийн тоо нь олон цөөн адлгүй арваад айл байж. Өрхийн тоо олныг нь их айл гэж, багыг нь айл гэдэг. Айлаа бага нэгжийг отор буюу тов гэдэг. Айл бүрд айлын Да гэж байна. Айлын Да-г мөн айлын хурлаар сонгож гаргадаг. Япон хэлний материалд айлын хурал буюу өвгөдийн хурал гэж тэмдэглэж буй. Нутгийн монголчууд бүгд айлын хурал гэж хэрэглэдэг. Айлын хурлын дарга нь нутгийн ахмад настай хүн байна. Харь хошууны хүнийг даргаар сонгохгүй. Гэхдээ айлын хурлын дарга Боржигон овгоос ондоо харц хүн байж болно.

Материал ховор учраас дээр үеийн айлын хурлын үйл ажиллагаа ямар байсан нь тодорхойгүй. Ер нь XX зууны эхний үед айлын хурал нь улиралд нэг хуралддаг, хуралд бэлчээр, нүүдлийн хэмжээ зай, овоо тахилгын тухай ярьна. Зүүн Үзэмчинд Ээж нуурын давсны аянг хийх тухай, Монгол амуу тарих газрын тухай үйлдвэрлэл хөдөлмөрт холбогдох учир явдлыг зөвлөн хэлэлцэхийн зэрэгцээ ардын хэрэг зарга, гэнэтийн хэрэг учир зэргийг шийдвэрлэхээр хуралддаг байжээ.

Энэ нутагт нутгийн овоо гэж байдаг. Жил бүрийн овоон тахилгыг нутгийн Да ноён эрхлэн явуулдаг. Бас овоон да гэж тусгай хүн томилж нутгийн итгэл хүндтэй ахмад энэхүү ажлыг хийдэг. Эдгээр ажил хөдөлмөрийг айлын хурлаар хэлэлцэж овоон тахилгын шүүс, морь уралдах, бөх барилдах, зэрэг уралдаж барилдах найрын шангийн мал, эдийг айл болгонд жил дараалан ээлжлэн даалгадаг.

Нутгийн ноён хэрэв улаан зэрэг, хөх зэргийн тайж бол 2-6 гошиго (зарц) дагуулж болдог, энгийн ноён 2-3 гошигтой. Хорчин зүүн гарын хойд хошуунд Бадаргуулт төрийн үед нутгийн ноёноо их Да хэмээж заримдаа залан гэнэ. Түүний

²³ 兴安局调查科《兴安南省扎赉特旗实态调查报告》1939年

доор дөрвөн аравны дарга байна. Аравны даргыг бага Да гэдэг. Чин улсын үед эл нутагт нутгийн харьяатаас хандиваар байгуулсан нутгийн сүмтэй. Ийм сүмийн сан мал тариаг нутгаас хамжин хавсарч эрхэлдэг байжээ.

Манж хаант улсын ноёрхлын үед хошуу чуулганы дүрмийг хасан, Хянганд дөрвөн муж болон өөрчилж муж хошуу, нутаг, гацаа, айл гэх таван дэсийн засгийн тогтолцоог байгуулжээ. Гэхдээ мөн нутаг гэх дуудлагыг үргэлжлэн хэрэглэхдээ эл хошуудын нутгын уул нэрийг өөрчлөн дугаарлаж тэмдэглэжээ. Жишээлбэл, дээр үеийн ямар ямар нутаг гэснийг 1, 2, 3-р нутаг гэж халж нэрлэжээ.

Өвөр Монголын өртөө засах засгийн ордон байгуулагдсаны дараа “нутаг” гэх дуудлагыг үргэлжлэн хэлэхдээ уул нутгийн нэрийг сэргээж хэрэглэсэн буюу өөрчилж дууджээ. 1980-аад онд байгуулагдсан Хянганд аймгийн Улаанмод нутаг нь XX зууны эцэс болтол үргэлжлээд бусад нутаг нь 1960-д оноос ардын нэгдэл болж хувирсан бөгөөд 1980-аад оноос сум гэж өөрчлөгджээ. Хэрвээ энэхүү нутгийн улирал хувьслыг түүхчилэн ойлгохгүй бол нутаг болон сум хоёрын ялгаа холбоог ойлгоход маш төөрөгдөлд хүрнэ.

Яг ийм учраас Жирмийн чуулганы арван хошуунд “нутаг” гэх засаг захиргааны нэгж сүүлийн үе болтол үлдэж ирсэн учир нь Хорчины язгууртан Чин улсын хааны угсаатай ургын холбоотой байж, Дайчин гүрнийг байгуулахад том зүтгэл үзүүлсэн болохоор Монголын уламжлалт эрхийг мэдрэн малжих нийгмийн үндсэн зохион байгуулалтыг үлдээн өгчээ²⁴. Нөгөө талаар Нон Хорчины язгууртнууд Чин улсын ноёрхолд дургүйцэж байсан буюу Чингийн засгийн ноёрхлыг ойшоохгүй байж, Хасарын уламжлалт сүр хүчний хэмжээгээ хадгалахыг зорьж байсны дүнд “нутаг” хэмээх зохион байгуулалт хэдэн зуун хадгалагдаж ирсэн гэж дүгнэж болохоор байна. Энэ тухай 1911 онд Манжийн ноёрхол нурсаны дараа Нон Хорчины хэдэн хошуу Богд хаант засагт эелдэн дагах улс төрийн хандлага тусгаар тогтнолын үйл ажиллагаа зэргээр гэрчилж болох юм.

Дүгнэлт

Тус өгүүлэлд Нон арван хошууны “нутаг” хэмээх зохион байгуулалтыг шинжлээд дараах хэдэн зүйлийн дүгнэлтэд хүрч байна. Үүнд,

Чин улсын үеийн Нон Хорчин арван хошууны харьяа зохион байгуулалт нь “нутаг” мөн. Нутаг бол малжих нийгмийн уламжлалт үндсэн зохион байгуулалт отгийн үргэлжлэл ажээ. Жалайд аймаг-Жалайд хошуу, Дөрвөд аймаг-Дөрвөд хошуу, Горлос аймаг-Горлос хошуу, Хорчин аймаг- Зүүн баруун гарын зургаан

²⁴ 兴安局调查科《兴安南省扎赉特旗实态调查报告》，1939年

хошуу зэрэг аймгаасаа хошуу болон хувирч чуулганд харьяалагдан, хошууны харьяа буюу хошуутай зэрэгцэн “нутаг” дагалдан байжээ. Иймээс Манж Чин улсын эрхшээлд орохоос өмнө эдгээр хошуудын нийгмийн бүтэц нь аймаг, нутаг, айл байсан бололтой.

Чин улсын үеийн Нон Хорчин арван хошууны нийгмийн гол бүтэц нь чуулган-хошуу-нутаг байсан бөгөөд харин чуулган-хошуу-нутаг-сум гэх хэлбэр маш бүрхэг байгааг харж болно. Ийм учраас Чин улсын үеийн Нон Хорчины нийгмийн засаг захиргааны бүтцийг хошуу чуулганы зохион байгуулалт бүхий нийгэм гэж хэлэхэд бэрх юм.

Эцэст анхаарах нэг асуудал бол Чин улсын үеийн Нон Хорчин хошуудын атар хагалбарлахыг эсэргүүцсэн тэмцэл болон ардын зан үйл зэрэг нь бүгд нутаг гэх зохион байгуулалттай холбоотой. Нутаг гэх зохион байгуулалтын харьцангуй тусгаарласан эрх мэдэл энэхүү орон нутгийн түүх соёлын өвөрмөц тогтолцоог харуулж байна.

Abstract: This article verifies the social organizations of ten banners in Non Khorchin in Qing Dynasty based on Japanese data and the field data collection in the first half of the 20th century. The social organizations are traditional Mongolian basic ones similar to otug. It was sustained in Horchin area after the 17th century and was broken in the 1940s. This illustrates the integration of league and banners system and existing social system under the reign of the Qing imperialism.

Ном зүй

1. 《扎赉特旗事情》，土屋定国，1937年。
2. 《兴安南省扎赉特旗实态调查报告》，兴安居调查科，1939年。
3. 《哲里木盟蒙地—从兴安省实地调查观察》，井手俊太郎，蒙古研究，1939年。
4. 《调查扎赉特旗报告书》，叶大匡、春德，1910年。
5. 《调查杜尔伯特旗报告书》，叶大匡、春德，1910年。
6. 《调查郭尔罗斯后旗报告书》，叶大匡、春德，1910年。
7. 《调查郭尔罗斯前旗报告书》，叶大匡、春德，1910年。
8. 《调查科尔沁右翼后镇国公旗报告书》，叶大匡、春德，1910年。
9. 《调查科尔沁右翼前扎萨克图郡王旗报告书》，叶大匡、春德，1910年。

10. 《调查科尔沁右翼中图什业图亲王旗报告书》，叶大匡、春德，1910年。
11. 《调查科尔沁左翼中达尔汗亲王旗报告书》，郭文田、程厚，1910年。
12. 《调查科尔沁左翼前宾图郡王旗报告书》，郭文田、程厚，1910年。
13. 《调查科尔沁后旗报告书》，郭文田、程厚，1910年。
14. 《科尔沁右翼后旗志》，1939年。
15. 《科尔沁右翼前旗志》，冯学中，内蒙古人民出版社，1991年。
16. 《科尔沁右翼中旗志》，贺希格杜荣，内蒙古人民出版社，1993年。
17. 《科尔沁左翼后旗志》，巴根那，内蒙古人民出版社，1993年。
18. 《科尔沁左翼中旗志》，赵海山，内蒙古文化出版社，2003年。
19. 《黑龙江少数民族部落史》，波少布、何日莫奇、哈尔滨出版社，2001年。
20. 《前郭尔罗斯蒙古族自治县志》，苏博，辽宁民族出版社，1993年。
21. 《清代蒙古蒙旗制度研究》，岡洋树，东方书社，2007年。
22. Владимирцов Б.Я. *Монголчуудын нийгмийн байгууллын түүх. Үндэстний хэвлэлийн хороо*: 1981
23. 《元朝秘史》，亦邻真复原，内蒙古大学出版社，1987年。
24. 《元朝秘史全訳》（上），小沢重男，風間書房，1984年。
25. 《アルタン=ハーン伝》，吉田順一，風間書房，1998年。